



САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.09.22 № 42

Монгол Улсын 2026 оны төсвийн
тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад заасныг тус тус үндэслэн дараах асуултыг Танд тавьж байна.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралт дахь Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад 2026 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Улсын хэмжээнд” гэсэн нэршил бүхий багц төсөл, арга хэмжээнүүдийг тусгасан байна.

Дээрх “Улсын хэмжээнд” гэсэн нэршил бүхий багц төсөл, арга хэмжээ тус бүрийн тодорхой байршил, хүчин чадал, хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээг тодорхойлсон тооцоолол, судалгааг төсөл, арга хэмжээ тус бүрээр гарган Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



М.БАДАМСҮРЭН

2025000065